



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 320

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1,2,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Стандарт, хэмжил зүйн газрын харьяа Увс аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн нийт 42,300,000.00 (дөчин хоёр сая гурван зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Стандарт, хэмжил зүйн газрын тамгын дарга Б.Эрдэнэзул, Увс аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга Г.Ууганбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1 Үндсэн хөрөнгийг дуудлагаар худалдах ажлын хэсэг томилж, холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2 Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 4 дүгээр улиралд багтаан мэдээ, тайлангийн баталсан маягтаар ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

0000637

C:\2019.07.22 16r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
2019 оны 07 дугаар сарын 22-ны
30-д дугаар тогтоодын х



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ХАРЬЯА УВС АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛСТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭ
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Явсан км	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал	Худалд үнэ (т
1	Суудлын автомашин, Тоёото Ланд Круйзер-100, 70-08 УВХ, JT111TJA008012581	1999/2011	245,240.00	42,300,000.00	42,300,000.00	-	9,702,000.00	9,70
Нийт дүн				(дөчин хоёр сая гурван зуун мянган)	(дөчин хоёр сая гурван зуун мянган)		(есөн сая долоон зуун хоёр мянган)	(есе долоо мян